



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3
<hr/>	
<i>Г.Горимын санал</i>	3

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий/-ны 05 дугаар сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут;

Тасалсан: П.Анужин.

Түр хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Хянан шалгах түр хорооны дотоод асуудал ярих учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 2

Бүгд: 8

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 03 минут үргэлжилж, 11 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр 09 цаг 18 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ

ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их Жанжин
Д.Сүхбаатар” танхим
09 цаг 15 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Ирцийг танилцуулъя, Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн, Хассуурийн Ганхуяг ирсэн байна, Цэрэнпилийн Даваасүрэн ирсэн, Ганзоригийн Тэмүүл, Наянтайн Ганибал гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна. Тогмидын Доржханд гишүүн орж ирж байгаа юм байна аа.

Ингээд ирц бүрдсэн тул өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдаанд хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Гурван асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай тогтоолын төсөл,

Хоёрт, Нотлох баримтыг шинжлэн судлах, дараалал тогтоох тухай тогтоолын төсөл,

Гуравт, Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай,

Дөрөвт, Бусад гэсэн хэлэлцэх асуудалтай өөр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Түр хорооны хорооны нотлох баримтыг шинжлэн судлах, дараалал түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах дараалал, Түр хорооны гэрчээр гэрчээр хувь хүнийг дуудах, гэрчээр дуудах хувь хүний мэдээллийн талаар ярилцах хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай учраас хаалттай хуралдах горимын саналыг гаргаж байна аа.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх талаар горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хаалттайгаар тийм тийм. 75 хувиар санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд оруулъя аа.

09.18 цагт

Бичлэгээс буулгасан:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА